

***УС ТҮГЭЭХ БАЙР-1 /БЗД, 27 ДУГААР ХОРОО/  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ***

**Тендер шалгаруулалт / *Ус түгээх байр-1 /БЗД, 27 дугаар хороо/*  
гэрээний нэр:**  
**Тендер шалгаруулалт /  
гэрээний дугаар: *НХААГ/201911849***

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**2019.11.08**

**Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Ус түгээх байр-1 /БЗД, 27 дугаар хороо/, НХААГ/201911849**–ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цаг 00** минутаас өмнө **цахим системээр** илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цаг 05 минутанд** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол улс, Улаанбаатар**  
**Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-57**  
**13 дугаар хороо, Засаг даргын Тамгын газрын байр,**  
**1 давхарт 121 тоот, Худалдан авах ажиллагааны алба Утас:70154446**  
**Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн

- саналын хүчинтэй байх хугацаа** хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>			
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 2017, 2018 оны аудитийн дүгнэлтийг нотариатаар баталгаажуулж ирүүлэх /тендер зарласан хугацаанаас хойш баталгаажуулах/</li> <li>2. Сүүлийн 2 жил ашигтай ажилласан байх: 2017, 2018 он</li> <li>3. Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл 2017, 2018 оны /гэрээгээр хийж гүйцэтгэсэн ажлуудийн гэрээний хуулбар, акт фото зураг/;</li> <li>4. Сүүлийн 2 жилийн /2017, 2018 он/ хугацаанд тус бүр дор хаяж 1 удаа санал болгож буй үнийн дүнгийнхэ 50 хувиас багагүй өртөгтэй ажил дээр үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.</li> <li>5. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жилийн /2017, 2018 он/ борлуулалтын орлого нь тус бүр санал болгож буй үнийн дүнтэйгээ дүйцэхүйц байна.</li> <li>6. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийнхэ 100 хувиас багагүй байна. *Үл хөдлөх хөрөнгийн болон бусад хөрөнгийн баталгаажсан гэрчилгээ /Үнэлгээний эрх бүхий байгууллагаар үнэлэгдсэн байх, Үл хөдлөх хөрөнгийн барьцаанд байгаа эсэх талаарх, Эд хөрөнгийн бүртгэлийн газраас гаргасан лавлагаа, барьцаанд тавихыг зөвшөөрсөн албан мэдэгдэл */Арилжааны банкны зээлийн тодорхойлолт /Хадгаламж зээлийн хоршоо болон Банк бус санхүүгийн байгууллагын тодорхойлолтыг тооцохгүй/</li> <li>7. Улсын бүртгэлийн гэрчилгээг эхээс хуулбарлан нотариатаар баталгаажуулсан байх /тендер зарласан хугацаанаас хойш/</li> <li>8. Татварын цахим тайлангийн системээс авсан цахим тодорхойлолт /Татварын өр төлбөргүй байх, Тендер зарласан хугацаанаас хойш тодорхойлолт авах/</li> <li>9. Харилцагч банкнаас өр авлагын талаарх тодорхойлолт</li> <li>10. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцоходоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн эсэх талаар шүүхийн тодорхойлолт /Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архивын тодорхойлолт болон Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт тус тус ирүүлнэ. /тендер зарласан хугацаанаас хойш/</li> <li>11. Тендерт оролцогч нь хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүй мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.</li> <li>12. Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлэх.</li> <li>13. Инженер техникийн ажилтнуудын диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар болон туршлагын талаарх мэдээллийг тендерийн хамт ирүүлэх.</li> </ol>			
	№	Албан тушаал	Хүний тоо	Ажилласан жилийн туршлага /жилээр/
	1	<i>Ерөнхий инженер</i>	<i>1</i>	<i>4</i>
	2	<i>Цахилгааны инженер</i>	<i>1</i>	<i>4</i>
	3	<i>ХАБЭА-н ажилтан</i>	<i>1</i>	<i>4</i>

Ерөнхий инженер, Цахилгааны инженер, ХАБЭА-ны ажилтан нь тухайн компанийн үндсэн ажилтан байна. /Тухайн байгууллагадаа тасралтгүй 4 жил болон түүнээс дээш жил Нийгмийн даатгал төлсөн байх./ ТҮЦ машинаас нийгмийн даатгалын тодорхойлолт авч ирүүлнэ.

14. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлнэ.
15. Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох програмаар гүйцэтгэнэ/. Хөнгөлөлт тооцсон тохиолдолд задаргаа болон үндэслэлийг ирүүлнэ. Ажлын төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181 дүгээр тушаал, БХБ-ын сайдын 2015 оны 185 дугаар тушаалаар батлагдсан барилгын норм ба дүрмийн дагуу тооцож программаар төсөв бодож ирүүлнэ. Мөн төсөв хийсэн төсөвчний гэрчилгээг эхээс хуулбарлан наториатаар баталгаажуулсан байх.
16. Захиалагч татвар болон харилцагч банкнаас тендерт оролцогчийн талаар тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх.
17. Тендерт оролцогчийг төлөөлөн гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу нотариатаар баталгаажуулан ирүүлэх.
18. Ажлын гүйцэтгэл болон хугацааны талаар нарийвчилсан график ирүүлэх
19. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэд багтаан барилгын ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.
20. Эхээс хуулбар хувь хийсэн материалууд нь чанарын шаардлага хангахуйц тод гаргацтай харагдахуйц хуулбарласан байх.

Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:

- **2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл орчны тохижилт**
- **2.1.2 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн барилгын ажил, өргөтгөл, шинэчлэлийн ажил /1-5 давхар хүртэл/**
- **2.2.2 барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангам, холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын систем угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралтын ажил гүйцэтгэх зөвшөөрөлтэй байна. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа тухайн ажлыг хийж гүйцэтгэх хугацаанд хүчин төгөлдөр байх шаардлагатай ба хэрэв тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа ажил гүйцэтгэж дуусахаар төлөвлөсөн хугацаанаас өмнө дуусахаар байвал түүнийг сунгахаар шийдвэрлэсэн эрх бүхий байгууллагын шийдвэрийг тендерийн хамт ирүүлнэ. /тендер зарласан хугацаанаас хойш/**

Шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалт түрээсээр болон хөлсөөр ашиглах техник, тоног төхөөрөмжийн гэрчилгээний хуулбар, түрээсийн гэрээний эх хувийг хавсаргах. Үүнд:

1. **Автокран 3тн-1ш**
2. **Ачааны автомашин-1ш**
3. **Бульдозер-1ш**
4. **Гагнуурын аппарат-1ш**
5. **Доргиур-1ш**
6. **Гүний доргиур**

<p><b>ТООЗ 2.1</b></p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> –д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэр /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100MB-с ихгүй, нэг файлын хэмжээ 15MB-с ихгүй байна.</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 13 хороо, Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба</i>  Давхар болон өрөөний дугаар: <i>1 давхар 121 тоот</i>  Огноо: <i>2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр</i>  Цаг: <i>10 цаг 00 минут</i></p> <p><i>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn-ийн</a> серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</i></p> <p><i>Тендер хүлээн авах хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалыг буцаан авах, засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй</i></p>
<p><b>ТООЗ 2.1</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байгууллагын хаяг: <i>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 13 хороо, Засаг даргын Тамгын газрын байр</i>  Давхар болон өрөөний дугаар: <i>1 давхар 121 тоот</i>  Огноо: <i>2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр</i>  Цаг: <i>10 цаг 05 минут</i></p>
<p><b>ТООЗ 2.3</b></p>	<p>Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:  <i>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</i></p>
<p><b>ТООЗ 6.2</b></p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Ус түгээх байр-1 /БЗД, 27 дугаар хороо/, НХААГ/201911849</i></p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Уг зураг төсөл нь Ус сувгийн удирдах газрын захиалгаар Улаанбаатар хотын бүх дүүрэгт баригдахаар төлөвлөх зөөврөөр ус хангах албаны ус түгээх байрны нэг маягийн зураг юм. Уг барилга нь тэнхлээгээрээ 4x9,95м хэмжээтэй ба тоосгон бүтээцтэй, модон хучилттай, шувуу нуруу дээвэртэй, зооргүй 1 давхар байхаар төлөвлөв гадна шугам сүлжээний зургийг техникийн нөхцлийн шаардлагын дагуу тухай бүрд нь боловсруулах ба нарийвчилсан тооцоо техникийн өгөгдөл шийдэл тайлбарыг хэсэг тус бүрээс үзнэ.

### АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

#### Газрын ажил

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
01-350-01	Барилга барих талбайг бульдозероор тэгшлэх	М2	267.5
01-210-01	Ургамалын үе хуулах	М3	40.125
01-050-02	Хөрсийг ухаж овоолох	М3	69.24
01-070-03	Хөрсийг гараар эргүүлж ухах	М3	43.25
01-550-05	Шалан доор шороо хийж нягтруулах	М3	5.52

#### Суурын ажил

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
06-010-04	Бетон бэлтгэл хийх В5	М3	1.85
06-010-22	Бетон шугаман суурь цутгах В15	М3	13.17
06-010-24	Усны савны доорх төмөр бетон суурь цутгах В15	М3	1.1
06-050-13	Усны савны доорх төмөр бетон суурь арматурчлах	Тн	0.113
06-010-22	Хамар хана, пийшингийн доорх суурь цутгах В15	М3	0.86
08-040-10	Суурийн ус тусгаарлагч битум түрхлэгээр 2 үе хийх	М2	56.48
08-300-04	½ өнгөлгөөний тоосгоор гадна хана өнгөлж өрөх	М2	71.3
08-050-10	120мм өргөн ердийн тоосгон хамар хана өрөх	М2	4.9
07-500-15	Ялуу я15.12.14	Ш	10
10-520-04	Модон ялуу хийж угсрах мя15.10.10	Ш	2
06-100-10	Төмөр бетон бүс цутгах В15	М3	2.1
06-050-13	Төмөр бетон бүс арматурчлах /зөрүү/	Тн	-0.1113
06-050-13	Ханын тор	Тн	0.16
08-250-07	Ханан пийшин тоосгоор барих	М3	2.16
08-250-10	Пийшингийн утааны яндан барих	М3	0.8

#### Хучилт, дээврийн ажил

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
10-080-04	Хучилтын банзан бамбай угсрах	М2	23.8
12-060-08	Уур тусгаарлагч үе хар цаас дэвсэх	М2	23.8
12-060-04	Хөөсөнцөр дулаалга хийх б=100мм g=35 кг/м3	М2	23.8
12-070-04	Хучилтанд 15мм зузаан тортой цементэн тэгшилгээ хийх	М2	23.8
12-070-05	Дараагийн 1мм зузаан тутамд үнэлгээ 30-д нэмэх	М2	119
10-100-04	Банзан шувуу нуруу угсрах	М3	1.06
06-050-10	Хучилтын бэхлэгээ төмөр хийц угсрах	Тн	0.02
10-350-06	Дээврийн парпетны хананд суух хэсгийн модон дам нуруунд ялзралаас хамгаалах хар тосон түрхлэг хийх	М2	4.32
12-150-04	Долгионт төмөр дээвэр хийх	М2	46.22



12-050-04	Барилгын гадна талын төмөр эдлэлүүд ус зайлуулах хоолойн хамт хийх	M2	64.5
-----------	--	----	------

**Шалны ажил**

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
06-010-04	Бетон шал цутгах B10 б=150мм	M3	3
11-060-04	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	M2	18.4
11-030-06	Усны өрөөнд ус тусгаарлагч 1 үе хар цаас	M2	10.9
06-010-04	Усны өрөөнд бетон шал цутгах B15 б=40см	M3	0.44
11-030-06	Бусад өрөөнд ус тусгаарлагч 2 үе хар цаас	M2	7.5
11-060-04	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	M2	7.5
15-410-06	Тамбур, шахмал түлш галын хэрэгсэлийн өрөөний шаланд плита наах	M2	2.65
11-220-11	Үйлчлэгчийн өрөөнд паркетан шал хийх	M2	4.9

**Шат, довжооны ажил**

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
06-230-06	Довжоог төмөр бетон гишгүүрийн хамж цутгах B15	M3	0.68
06-050-13	Довжоог төмөр бетон гишгүүр арматурчлах /зөрүү/	Tн	0.11
06-010-04	Хаяавч цутгах B5	M3	3.25
11-060-04	Хаяавчинд 20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	M2	32.5
10-670-04	Гадна листэн хаалганд хэрэглэл угсрах	Иж бүрдэл	1
10-180-04	Дотор модон хаалга угсрах	M2	3.4
10-180-04	Гүйдэг хаалга угсрах /1,2*2,5/	M2	3
10-670-04	Модон хаалганд хэрэглэл угсрах	Иж бүрдэл	3
10-600-04	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих	M2	6.4
10-600-05	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	M2	1.04

**Дотор заслын ажил**

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
15-040-12	Хананд сайн чанартай шавардлага хийх	M2	70,05
15-050-05	Хаалга цонхны амалгааг өндөр чанартай шавардах	M2	1,64
15-240-08	Хананд замаск хийх	M2	70,05
15-200-10	Дотор хана тосон будгаар гар аргаар ердийн будах	M2	20,116
15-310-18	Эмульсээр хана будах	M2	49,93
10-090-07	Усны өрөөнд гөлмөн төмрөөр модон тааз бүрэх	M2	10,9
10-090-06	Ус түгээгчийн өрөө тамбур, шахмал түлш, галын хэрэгсэлийн өрөөнүүдийн таазыг 5-мм-ийн зузаан өнгөт хуулгатай эслэг хавтангаар бүрэх	M2	7,5
10-020-09	Цэвэр банзан эмжээр бүх таазанд хадах /карниз/	M2	31,66

**Далангийн ажил /пандус/**

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
06-010-24	Далангийн хашлага төмөр бетон хана цутгах B15	M3	30.93
06-050-13	Далангийн хашлага төмөр бетон хана арматурчилах /зарүү/	Tн	-0.41
15-140-04	Далангийн түшиц хана шохойн будгаар гар аргаар будах	M2	52.5
01-190-07	Даланд шороо нэмж хөрсийг өндөр бүтээмжтэй хийн громбовкоор нягтруулах	M3	61.92
06-010-04	Даланд хаяавч цутгах	M3	0.6

## Ус шүүрүүлэх талбай

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
01-050-03	Хөрс гараар ухах	М3	2.25
50-030-01	Шүүрүүлэх худгийн уланд хайрга асгаж тэгшлэх, нягтруулах	М3	0.45
21-230-05	Худгийн бетон цагираг угсрах d=1500мм	Ш	1
08-040-10	Цагиргийн хананд ус тусгаарлагчийг битум түрхлэгээр 2 үе хийх	М2	9.42
31-170-01	Төмөр сараалжин таг тавих 1,5*1,5	1 ширхэг	1
10-670-04	Төмөр сараалжин таганд цоож нугас угсрах	Иж бүрдэл	1
06-010-04	Шүүрүүлэх талбайд бетон цутгах	М3	0.4
11-060-04	Бетон талбайд цементэн тэгшилгээ хийх	М2	4
01-050-03	Автомашиньг хориглох хашлага хийх бетон шонгийн 5ш нүх гараар ухах /0,4*0,4*0,4*5/	М3	0.32
30-230-01	Автомашиньг хориглох хаалт төмөр бетон шон босгох	Ширхэг	5

### Дотор гэрэлтүүлгийн ажил

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
20-270-04	Хананд далд тавих гэрэлтүүлэг ба хүчний самбар угсрах	Ш	1
38-400-61	2 туйлт автомат ВА47-100. 2P. Lx=100A.-x-ka-Салгуур=25А-1ш	Ш	1
30-370-01	Цэнэг шавхагч ОПС1-С/4-1ш. Гал хамгаалагч-3ш	1 иж бүрдэл	1
38-540-04	1 фазын электрон тоолуур угсрах 40А	Ш	1
38-400-61	Шугаманд 2 туйлт автомат ВА47-29.2P.lc=16А х-ka-B	Ш	2
38-400-61	2 туйлт диффеоенциаль автомат АД-12.2P lh=16А lдп=10мА	Ш	1
38-400-61	2 туйлт диффеоенциаль автомат АД-12.2P lh=16А lдп=30мА	Ш	1
20-230-05	Хананд далд тоноглох 1 даралттай унтраалга угсрах IP20	Ширхэг	3
20-230-05	Хананд далд тоноглох 3 даралттай унтраалга угсрах IP20	Ширхэг	1
20-230-08	Хананд далд тоноглох 2-лсон розетка угсрах IP20	Ширхэг	3
20-230-08	Хананд далд тоноглох газардуулагч контакттай 2-лсон розетка угсрах IP20	Ширхэг	2
20-250-05	Эрчим хүчний хэмнэлттэй чийдэнтэй ус чийгнээс хамгаалагдсан мемалл тортой таазнаас зүүх гэрэлтүүлэгч угсрах IP54	Ширхэг	3
20-250-05	Хананд ил тавих хамгаалагдсан гэрэлтүүлэгч угсрах 60ВТ 220В IP-54	Ширхэг	3
20-250-08	2*36ВТ өдрийн чийдэнтэй таазанд тавих гэрэлтүүлэгч угсрах IP-20 /ЛПО317-2*36/	Ширхэг	1
38-520-09	Розетка унтраалгын блок угсрах	Ш	7
38-440-05	Далд утас салбарлах хайрцаг угсрах	Ширхэг	3
20-170-04	1*2,5мм2 хөндлөн огтлолтой зэс утас сүвлэх	М	130
20-160-10	Хуванцар хоолой угсрах d-20мм2 IP55	Метр	60

### Халаалтын ажил

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
38-540-06	Цахилгаан халаагч угсрах Q=750Вт 220V/50Hz	Ш	1
38-540-06	Цахилгаан халаагч угсрах Q=950Вт 220V/50Hz	Ш	2

### Салхивчийн ажил

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих	Тоо
----------	---------------------	--------	-----

		нэгж	Хэмжээ
19-030-04	0.7 мм зузаан гөлмөн төмрөөр хийсэн агаар дамжуулах тэгш өнцөгт огтлолтой хоолой угсах	М2	8
19-100-07	Агаар сорох сараалжин жааз угсах P150 Fo=0.015м2	Ш	3

#### Цэвэр усны ажил

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
16-072-08	D=80мм голчтой ган хоолой угсах	М	5
16-072-05	D=50мм голчтой ган хоолой угсах	М	9
16-280-04	Пластмасан хоолой ф 15 мм	М	3
16-110-05	Вентиль d=32мм	Ш	3
16-110-04	Вентиль d=15мм	Ш	1
18-090-04	Хог шүүгч тавих ф32	Ш	1
16-170-04	Усны тоолуур угсах ф15	Ш	1
09-560-04	Төвшин хамжигч хэрэслийг угсах	Ш	1
18-050-12	Цэвэр усны нөөцийн сав тавих W=8м3	Ш	1

#### Бохир усны ажил

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
16-270-05	Бохир усны хуванцар хоолой d-100	М	20
16-270-04	Бохир усны хуванцар хоолой d-50	М	1
16-250-04	Ташуу гуравлагч ф100*100	Ш	1
16-250-04	Ташуу гуравлагч ф100*50	Ш	1
16-250-04	Отвод ф 100	Ш	4
16-250-04	Отвод ф 50	Ш	1
16-250-04	Колено 90*ф 50	Ш	2
61-040-01	Шалгах таглаа тавих 100мм	Ш	1
18-090-05	Ус цуглуулах шүүр ф100	Ш	1
19-140-04	Малгайвч угсах ф100	Ш	1
17-010-07	Угаагуур угсах	Ш	1
09-570-04	Угаагуурын лонхон сифон хаалт угсах ф 100	Ш	1
16-060-05	Угаагуурын уян хоолой угсах	М	1

#### Галын дохиолол

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
40-280-04	Галын дохиоллын хүлээн авах станц	Ш	1
39-150-54	Галын дохиоллын хянах самбар	Ш	1
40-320-05	Утаа мэдрэх галын дохиоллын мэдээллэгч I=100мкА Rх-1.1kOm	Ш	3
40-360-04	Гараар удирдах галын дохиоллын мэдээллэгч /телефон утасны холбогчтой/ I=100мкА Rх-1.1 kOm	Ш	1
40-360-05	80дб авиа хүртэл авиа үүсгэх түгшүүрийн дуут дохио өгөгч	Ш	1
38-270-62	Зэс дамжуулагчтай полиэтилен тусгаарлагчтай галд тэсвэртэй бүрээстэй утас сүвлэх / дохиололын зориулалттай/ 2x2x0,5мм	М	16
38-270-62	Зэс дамжуулагчтай полиэтилен тусгаарлагчтай галд тэсвэртэй бүрээстэй утас сүвлэх / дохиололын зориулалттай/ 1x2x0,5мм	М	4
20-160-04	Хуванцар хоолой ф16мм /нимгэн ханатай/	Метр	20

#### Гадна тохижилтийн ажил

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
06-080-07	Цэцгийн мандалын хашлага бетон хана цутгах	М3	2
01-070-02	Цэцгийн мандалд шороо хийх	М3	3

37-110-04	Цэцгийн мандал доорхи хар шороог 20 см зузантай хийж бэлтгэх	М2	5
37-100-09	Зүлэг ба шилэн хүлэмжинд үржүүлсэн суулгацийг гараар хийх	М2	5
25-07-20	Явган хүний замын суурийг элс-хайрганы хольцоор хийх	1м3	0.3
25-07-22	Явган хүний замын хучилтийг өнгөт хавтангаар хийх /1м2-д 16-50ш хавтан/	1м2	3
25-12-01	Явган хүний замын хашлага тавих	1у/м	4.03

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**  
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b><br>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах,



хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх** 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

#### Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Ус түгээх байр-1 /БЗД, 27 дугаар хороо/, НХААГ/201911849</i>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <i>Ус түгээх байр-1 /БЗД, 27 дугаар хороо/-</i> аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>21 дүгээр хороо</i> -д байрших ба зураг-д зааснаар тодорхойлогдсон болно.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь: <i>Гэрээнд заагдсан этгээд байна.</i>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр: <i>Гэрээнд заагдсан өдөр байна.</i>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: <i>Гэрээнд заагдсан өдөр байна.</i>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 8 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <i>[тоо]</i> хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

### **[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;

- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]